

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсандамдин	Дугаар	L358
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Дэлгэрцогт сум
Төрсөн газар	Дэлгэрцогт сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	Тэргүүн лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дэлгэрийн Чойрын хийд	Сүм хийдийн дугаар	ДУДЦ 034
Одоогийн сүм хийд	Дэлгэрийн Чойрын хийд	Сүм хийдийн дугаар	ДУДЦ 035
Ярилцлага авсан он сар өдөр	2007 он 7-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Жужа, Энхбаяр



Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Дэлгэрийн Чойрын хийд

Жужа: Та Дэлгэрийн Чойрын хийдийн түүхээс ярьж өгнө үү?

Лувсандамдин: За Дэлгэрийн Чойрын хийд бол шинэ үеийн хийд л дээ. 19-р зууны сүүл 1918 онд анх шав тавьсан. Түүх нь урд дөрөвдүгээр Богд баруун зуу ороод буцахдаа хэд хэдэн газар үдэлж Цагаан лавай гэж байдаг ш дээ. Дун татсан гэдэг. Тэдгээр газруудын нэг нь энэ Дэлгэрийн уулын өвөр байж. Тэгээд Дэлгэр уулын энгэрт татсан тэр өрөөлөөр одоо бүрдсэн гэж үздэг. Тэгээд дараахан нь энэ Дэлгэр уулын энгэрт тэр газарт энэ ойр хавийн жасын хүүхдүүд ирж ном хаялцаад, том чулуун дээр сүүчихээд тэдгэд болсон гэдэг. Улмаар нутгийн лам нар тухайн үеийн нэр Дайчин бэйсийн хошууны ноён Мөнх-Очир гэж ноёнд энэ их хиуртай газар байсан аа хийд орон байгууллавал яасан юм гэж айлгахад Мөнх-Очир ноён Заваа Дамдин гэж хоёр зөвлөлдөн Сэтвийн Гүртэн багш гүртэм буулгуулахад энд хийд орон байгууллавал номын буян хишиг дэлгэрнэ гэж айлджээ. Тэгээд энэ хийдийг байгуулсан юм гэж үздэг юм. Тэгээд наймдугаар богдоос шагнасан ялмай пайлууртай хийд байсан гэдэг. Ялмай пайлуур гэж та нар мэднэ ш дээ. Манжийн хаанаас олгодог хааны зарлигтай ямбаны хэрэгслэл л дээ. Наймдугаар богдоос манган ламын эрхээр шагнаж энэ бол тухайн үед ч гэсэн хийд оронд ийм олон ламын эрх өгдөггүй байж, манган ламын эрх гэж. Тухайн үед ч гэсэн хууль цаазтай байж. Тэгээд бас Чоёнотчилин

Энэхүү нар дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагын хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гэсэн нэр өгчээ. Анх байгуулагдахдаа Ганданчойндорлин гэсэн нэртэй байсан гэнэ лээ. 1918 онд. За Заваа Дамдин гуяа бол Ганданд Гунгаачойлин дацанд чойрын ном үзэж гэж болсон. Сүүлдээ агийн ном ч үзэж байсан. Шавь нараас нь аграмбын дамжаа барьсан хүн олон байсан гэдэг. Өөрөөр болохоор аграмбын дамжаа барихгүй гээд бариагүй юм гэнэ лээ. Ер нь тэгээд гүн ухааны номлолд гаргуун гэдгийг хүн болгон мэднэ ш дээ. Тэгээд л чойрын номыг судалж байсан байх. Анх байгуулагдаж байхдаа архивын баримтанд 600 гаруй лам гэсэн тоо байдаг юм. Өвөгчүүлийн яриагаар 800 ламтай байсан гэдэг. Энэ дотор залуу лам нар их олон байж. Тэр залуу лам нарыг Заваа Дамдин гуяа өөрөө чойрын номд сургаж байж. Чойрын ном нь Сономдагвын ичмаагаар, гүнчингийн ичмаагаар голлож явагддаг байсан гэсэн. Энэ Дэлгэрийн уулыг чинь Дэлгэрцогтын уул гэдэг юм. Хүмүүс ихэнхдээ Дэлгэрийн уул гэдэг. Энэ уулын өвөр дэх хийд нь голчлон чойрын ном дагнадаг байсан тул энэ хоёроос улбаалан анхнаасаа л Дэлгэрийн Чойр гэдэг нэрээр алдаршсан юм, энэ хийд. Харин албан ёсоор хаанаас хайрласан нэр нь Чоёнотчилин. Төвд нэр нь Ганданчойндорлин юм. За хүмүүсийн дунд л Дэлгэрийн чойр, Дэлгэрийн чойр гээд л нэрлэгдсэн юм. Тэгээд Заваа Дамдин гуяа 1936 оны намар Да Хүрээ орж өвөлжиж, 1937 оны зуны эхэн сарын хорин таванд таалал болоход шавь нар нь шарилж нь авчирч энэ цамын үс гэдэг газар хайлуулжээ. Тэгээд л тэр бараг л хайлуулсан өдрөөс нь баривчилгаа эхэлж сүм хийдийг нурааж эхэлсэн гэнэ лээ. Харин засаг бол хороочихоогүй бие нь чилээрхээд, өвчнөөр өөд болсон юм гэнэ лээ. Тэр 1936, 1937 онд Заваа Дамдин гуяаг эзгүйд Жаал Шарав гэж их номтой лам хамба хийж байсан. Ингээд л сүм хийд хаагдсан. Жаал Шарав гуяа бол харин амьд гарч 1960-аад оныг хүртэл энэ хийдийнхээ туурин дээр нутаглаж байсан хүн гэнэ лээ. Жаал Шарав гуяатай цуг тэр үеийн хэдэн хөгшчүүл лам нар байсан юм гэнэ лээ. Жамбал гуяа, Даваа гуяа, Мятав гуяа гээд олны танил болсон хүмүүс байсан. За Жаал Шарав гуяа үг нь энэ хийдийнхээ бурхан шүтээн ном судрыг маш сайн нууж хамгаалж үлдэж чадсан юм гэнэ лээ. Хүүчин засгийн үед гурван ч удаа ирж, нэгжиж байсан юм гэнэ лээ. Тэр хатуу хналт, тэгнүүл түршуул дор бас нуугаад л хурал хааяа хураад л байсан гэдэг. Жаал Шарав гуяа ч өнгөрч бурхан тахил, ном судар нь Гэмлэл гуяаг өвлөгдөж үлдсэн гэж байгаа. Тэгээд 1990-ээд онд сүм хийд сэргээхэд Гэмлэл гуяа тэргүүтэй хэдэн хөгшчүүл энэ туурин дээр хоёр дуган барьсан нь суурийн муугаас болоод цууралт өгч шаардлага хангахгүй болж. Тэгээд буцааж нураасан юм гэнэ лээ. Тэгээд гэрт хурж байгаад тэр үедээ үлдсэн цөөхөн хэдэн хөгшчүүл хэдэн банди нар байж. Удалгүй лам нар ч цөөрч хөгшчүүл ихэнх нь таалал болж, банди нар нь сургууль соёл ажил төрлийн мөр хөөж хурал эзгүйрчээ. Гэмлэл гуяа ч өнгөрч, энэ үеэс Гэмлэл гуяйн хөгшин Лхам гэж эмээ одоо ч амьд байгаа. Лхам эмээ энэ хийдийн туурийг сахиж нутаглаж болж. Сахиус бурхад ном судар нь, хөгшчүүдийг өнгөрсөн хойно ганц нэг нь алдагдсан юм шиг байгаа юм. Гэмлэл гуяа ч зарим нэгийг нь Ганданд өргөж ойр хавийн хурал дацангуудад ч өргөсөн гэдэг. Үлдсэн бурхан тахил, ном судар нь Лхам эмээд хадгалагдсаар өнөөдрийг хүрсэн. Тэгээд л бид хэд 2004 онд энд анх ирж үзсэн юм. Тэгээд нутгийн олонтой уулзаж аймаг орж аймгийн удирдлагуудтай уулзаж ерөнхий байдалтай танилцсан. Тэгээд хүмүүс бид нарыг энд ирж хийд хурлыг сэргээгч гэж урьж залсан л даа. Тэгээд бид нар 2005 оны хавар ирж энд суурьшин тэр жилдээ багтаан энэ хоёр дуганыг барьж ашиглалтанд оруулсан юм. За энэ хүүхдүүд бол бүгд Амарбалсгалант хийдэд сүмж байсан

Энэхүү нар дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагын хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хүүхдүүд. Би ч өөрөө Амарбалсгалантад сууж байсан. Тэгээд л одоо энд ирээд бурхан шүтээнээ залж хурал номоо сэргээж, аль чадахдаараа л байж. Манай шашны язгуур үндэс болох шар малгайны ёсыг жинхэнэ утгаар нь бэхжүүлэн хөгжүүлэх дан ганц шашнаас гадна түүх соёлоо хөгжүүлэн хамгаалах олон л юм санаж байна. Манай энэ гол дуган бол Мандширын дуган, аль Заваа Дамдин гуяйн үеэс л ийм дуган байсан юм гэнэ лээ. Хуваргыг ариутгагч мандшир гэдэг ийм нэртэй. Энэ дуганы гол бурхан нь мандшир, оюун ухааны бурхан. Лам нар нь оюун билгээ хурцалж, жамбал цанжид их уншиж, Чойрын ном үзнэ. За тэр хуваргыг ариутгагч мандшир гэдэг нь дээр үеийн нэр. Тэгвэл бид шинэ сэргээсэн мандшир дуганаа мандширыг байсгагч сүм гэж нэрлээд байгаа. Энэ бас учиртай. Урд Заваа Дамдин гуяйг шавь нар нь мандширыг байсгагч буяны садан гэж нэрлэж байсан гэдэг. Үүнтэй холбоотой. Энэ өргөөг Бадаргуулт цагаан гэрэлт өргөө гэдэг. Энэ нь хорин ханатай 216 уньтай, 12 баганатай. Яг л монгол өргөө. Энэ хавьдаа л хамгийн анх баригдсан том өргөө. Хүүчин түүхэнд бол Автай хааны өргөө гэж их том өргөөний туурь Эрдэнэзүүд бий л дээ. Бас анх өндөр гэгээнийг залахад их цагаан орд өргөө барьж, их хурлыг тогтоов хэмээн түүхэнд бичсэнгүй уншаад их билгээжээсэн. Ерөнхийдөө гэр дуган л гэсэн үг л дээ. Одоогоор сахиус шүтээнээ энд залчихаад байгаа. За мандширын дуганыг барьсан нь энэ лам нар төдийгүй хүн ардын оюун билгийн мэлхийн хурц тунгалаг байг гэдгийг л их билгээжээсэн дээ. Одоо энд хотоос архитектор хүмүүс ирчихээд байгаа. Манай сахиусан дуганы зургийг гаргах юм. Бид тэгээд сахиусан дуганаа ойрын үед барина. Ер нь манай хийдийн хийдийг сахиж байдаг сахиус бол Сэтэв сахиус.Номын сахиус нь Доржжүгдэн сахиус, за энэ нь учиртай Заваа Дамдин гуяйн багш их хүрээний номч мэргэн Минжүүр Дорж гэдэг хүн цөвүүн цаг эхлэхэд Доржжүгдэн сахиусыг тахиж байгаарай гэж захисан гэдэг. За Балдан лам сахиус бол нэн эртнээс тахиж ирсэн уламжлалтай. За өөрөөр хэлбэл манай хийд ерөнхий гурван сахиустай, Сэтэв, Лхам, Доржжүгдэн гээд. Бас арван хангал гээд шашны сахиусуудыг тахина. За маншир дуганд язгуурын таван мандшир байгаа. Их өргөөнд Доржжүгдэн бий. Мөн маш сайхан эзэт наамлын эргаар урласан Лхам сахиус байгаа. За Заваа Дамдингийн сүүж байсан нэг гэр одоо энд манай хийдэд бий. Нэг гэр аймгийн музейд байдаг. Тэр гэр их сонин гэр. Сархинаган тоонотой, зөвхөн говьд байдаг. Бургасан уньтай, хана нь ч өвөрмөц. Одоо энэ зун номын баяраар музейгээс гаргаж аймгийн ЗДТГ-ын өмнө барьж, нийтэд үзүүлэх юм гэсэн. Тэр гэр дотор Заваа Дамдингийн мөнгөөр хийсэн нэгэн хөөмөл хөрөг бий. Тэрнийг 2005 онд манай багш бид хоёр урласан юм. Эх зураг нь манай хийдэд уламжлагдаж ирсэн нэгэн зурагнаас авсан.

Жужа: Одоо ямар ямар хурал хурж байна?

Лувсандамдин: Өдөр тутмын сар улирал жилийн дүйсэн өдрүүдэд хурдаг бүх хурлын жагсаалт, та нарт өгсөн календарь дээр байгаа. Тэндээс хараад биччих. өдөр тутамд цогчингоос гадна банди нар өөрийнхөөхүсэл эрмэлзлэээр номоо судална, сонирхсон ухааны номнуудаа судална. Бясалгал хийнэ. Мөн заслын номууд унших болвол уншина. Дээр нь хүүчин монгол бичиг, калиграфын хичээл орно. За тэгээд ер нь бясалгал их хийнэ.

Жужа: Одоо хэдэн лам нар байна?

Энэхүү нар дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагын хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

3

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсандамдин: Чи гадаа гараад тоолчих / инээв /. Том эрдэнэ чадалтай зэрэг зиндаатай лам нар бол байхгүй одоо. Бүх юм л эхнээсээ эхэлж байна гэж бодож болно.

Энхбаяр: Гадуур байгаа суварганууд?

Лувсандамдин: За энэ хойно байгаа том суварга хүүчин Заваа Дамдин гуяйн үед байсан суварга. Түмэднамнигийн суварга. Тойроод найман жижиг суварга бий. Нураачихсан байсныг нь Гэмлэл гуяа, үр хүүхдүүд нь энэ тэр сэргээсэн гэнэ лээ. Шүншигэнд нь харин хүүчний нь юмнууд орсон гэнэ лээ.Цаана нь нэг хоёр чулуун суварга байгаа.

Энхбаяр: Гадаад дотоодын хийдүүдтэй холбоотой юу?

Лувсандамдин: Гандантай холбоотой байдаг юм, Сонинбаяр ламтай холбоотой. Цаашаа Булганы хийдтэй холбоотой. За Энэтхэгийн Сира дацантай холбоотой. Швецарит байдаг буддын нэг сүмтэй холбоотой байдаг.

Энхбаяр: Гэлэн сахилтай лам нар олон үү?

Лувсандамдин: Хориос дээш насны лам нар бүгд гэлэн.

Жужа: Майдар эргэдэг үү, танайх?

Лувсандамдин: Майдар эргэнэ. Хоёр дахь жилдээ эргэж байна. Тэнд байгаа жууз тэрэг майдрын жууз. Зуны эхэн сарын 25-нд эргэдэг юм. Заваа Дамдин гуяйн таалал болоход шавь нар нь шарилж нь авчирч энэ цамын үс гэдэг газар хайлуулжээ. Тэгээд л тэр бараг л хайлуулсан өдрөөс нь баривчилгаа эхэлж сүм хийдийг нурааж эхэлсэн гэнэ лээ. Харин засаг бол хороочихоогүй бие нь чилээрхээд, өвчнөөр өөд болсон юм гэнэ лээ. Тэр 1936, 1937 онд Заваа Дамдин гуяаг эзгүйд Жаал Шарав гэж их номтой лам хамба хийж байсан. Ингээд л сүм хийд хаагдсан. Жаал Шарав гуяа бол харин амьд гарч 1960-аад оныг хүртэл энэ хийдийнхээ туурин дээр нутаглаж байсан хүн гэнэ лээ. Жаал Шарав гуяатай цуг тэр үеийн хэдэн хөгшчүүл лам нар байсан юм гэнэ лээ. Жамбал гуяа, Даваа гуяа, Мятав гуяа гээд олны танил болсон хүмүүс байсан. За Жаал Шарав гуяа үг нь энэ хийдийнхээ бурхан шүтээн ном судрыг маш сайн нууж хамгаалж үлдэж чадсан юм гэнэ лээ. Хүүчин засгийн үед гурван ч удаа ирж, нэгжиж байсан юм гэнэ лээ. Тэр хатуу хналт, тэгнүүл түршуул дор бас нуугаад л хурал хааяа хураад л байсан гэдэг. Жаал Шарав гуяа ч өнгөрч бурхан тахил, ном судар нь Гэмлэл гуяаг өвлөгдөж үлдсэн гэж байгаа. Тэгээд 1990-ээд онд сүм хийд сэргээхэд Гэмлэл гуяа тэргүүтэй хэдэн хөгшчүүл энэ туурин дээр хоёр дуган барьсан нь суурийн муугаас болоод цууралт өгч шаардлага хангахгүй болж. Тэгээд буцааж нураасан юм гэнэ лээ. Тэгээд гэрт хурж байгаад тэр үедээ үлдсэн цөөхөн хэдэн хөгшчүүл хэдэн банди нар байж. Удалгүй лам нар ч цөөрч хөгшчүүл ихэнх нь таалал болж, банди нар нь сургууль соёл ажил төрлийн мөр хөөж хурал эзгүйрчээ. Гэмлэл гуяа ч өнгөрч, энэ үеэс Гэмлэл гуяйн хөгшин Лхам гэж эмээ одоо ч амьд байгаа. Лхам эмээ энэ хийдийн туурийг сахиж нутаглаж болж. Сахиус бурхад ном судар нь, хөгшчүүдийг өнгөрсөн хойно ганц нэг нь алдагдсан юм шиг байгаа юм. Гэмлэл гуяа ч зарим нэгийг нь Ганданд өргөж ойр хавийн хурал дацангуудад ч өргөсөн гэдэг. Үлдсэн бурхан тахил, ном судар нь Лхам эмээд хадгалагдсаар өнөөдрийг хүрсэн. Тэгээд л бид хэд 2004 онд энд анх ирж үзсэн юм. Тэгээд нутгийн олонтой уулзаж аймаг орж аймгийн удирдлагуудтай уулзаж ерөнхий байдалтай танилцсан. Тэгээд хүмүүс бид нарыг энд ирж хийд хурлыг сэргээгч гэж урьж залсан л даа. Тэгээд бид нар 2005 оны хавар ирж энд суурьшин тэр жилдээ багтаан энэ хоёр дуганыг барьж ашиглалтанд оруулсан юм. За энэ хүүхдүүд бол бүгд Амарбалсгалант хийдэд сүмж байсан

Энэхүү нар дурдсан хүний амьн ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагын хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

4